



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
Шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 122,000,000.00 (нэг зуун хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 67,932,454.80 (жаран долоон сая есөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг наян мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Монгол улсын их сургуулийн харьяа Шинжлэх ухааны сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Я.Нямжаргал, Монгол улсын их сургуулийн харьяа Шинжлэх ухааны сургуулийн захирал Д.Заяабаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашины улсын дугаар, эзэмшигчийн гэрчилгээг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Д.Нарангэрэл



- 132001472

\Huraldaanii material\2021 он\2021.06.15 10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны дугаар сарын 1-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт



“Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй, Монгол улсын их ургуулийн харьяа Шинжлэх
ухааны сургуульд балансад шилжүүлэх автомашин

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрайзер прадо 150, 44-67 УНП (арал-jtebx3fj40k293259)	2018	122,000,000.00	67,932,454.80	54,067,545.20
	Нийт дүн		122,000,000.00 (нэг зуун хорин хоёр сая)	67,932,454.80 (жаран долоон сая есөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг наян мөнгө)	54,067,545.20 (тавин дөрвөн сая жаран долоон мянга таван зуун дөчин таван төгрөг хорин мөнгө)

-000-